

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Боловсролын салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Алтантүлхүүр Танан-Эрдэнэ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн , дууссан хугаца	Биелэлтийн хувь
1.1. Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг" арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
1	Ерөнхий боловсролд "Цөөн хүүхэдтэй анги" арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих	Шалгалтад хамрагдсан сургуулийн тоо	-	Шалгалтад хамрагдсан сургуулийн тоо - 80	Тайлант хугацаанд буюу 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн 34, орон нутгийн 45 буюу нийт 79 ерөнхий боловсролын сургуулийг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулснаас нийслэлд 8, орон нутагт 26 буюу 34 сургуулийн 636 бүлэгт /32.2%/-д нь бүлэг дүүргэлт нормоос хэтэрсэн үзүүлэлттэй байна. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтад нийслэлийн 31, орон нутгийн 9 буюу нийт 40 сургуулийг хамруулснаас нийслэлийн 8, орон нутгийн 6 буюу нийт 14 сургуулийн 304 бүлэгт хүүхдийн тоо нормоос хэтэрсэн байна.	5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1.2. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль							

тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх							
2	Боловсролын салбарын болон хяналт шалгалтын холбогдох хууль, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгөх, хяналт шалгалтын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо	-	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 1	Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг боловсруулж байна.	5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3	Ерөнхий боловсролын сургуулийн гадаад, дотоод орчны стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа эсэхэд холбогдох байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчил арилгалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	Хяналт шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 60% Илэрсэн зөрчил арилгалтын хувь - 55% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 0	Хяналт шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 50% Илэрсэн зөрчил арилгалтын хувь - 35% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 50%	Боловсролын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбар улсын ерөнхий байцаагчдын хамтран баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын гадаад, дотоод орчны стандартын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж"-ийн хүрээнд аймаг, нийслэлийн орон нутгийн байцаагчдад стандарт, журмуудыг хүргүүлж, арга зүйгээр ханган ажиллаж байна	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

4	Боловсролын салбарын хяналтын чиглэлээр нийслэл, орон нутагт их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 145 объектод төлөвлөгөөт шалгалт хийх ажлыг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Албан шаардлагын хэрэгжилтийн хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	2024 оны гүйцэтгэлийн түвшингээр	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 45% Албан шаардлагын хэрэгжилтийн хувь - 40% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 60%	Боловсролын салбарын хяналтын чиглэлээр нийслэл, орон нутагт их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 145 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар нийслэлд 34, орон нутагт 45 буюу нийт 79 ерөнхий боловсролын сургуулийг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан байна. Хяналт шалгалт 54.5 хувьтай үргэлжилж байна. Нийслэлийн Боловсролын газрын боловсролын хяналтын улсын байцаагчдыг шалгалтын явцад арга зүйгээр хангаж ажилласан.	4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Сүхбаатар, Дундговь аймгийн боловсролын сургалтын байгууллагуудад нэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	-	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 60% (2) Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь - 60% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 45%	Тус яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/18 дугаарын удирдамжаар Сүхбаатар аймгийн зарим боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг боловсролын хяналтын чиглэлээр батлагдсан хяналтын хуудсуудад заасан асуудлын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын 5 сургуулийн үйл ажиллагааг 03/6.1-2 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 68.9, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 28.1-тэй буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-2, дунд-3, ерөнхий боловсролын 3 сургуулийн суралцагчдын дотуур байрны үйл ажиллагааг 03/6.1-5 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль	5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сахин мөрдөлтийн дундаж хувь 73, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 25.9-тэй буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-1, дунд-2 байна. Шалгалтад хамрагдсан хүүхдийн 5 цэцэрлэгийн үйл ажиллагааг 03/6.1-1 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 76.4, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 23.9-тэй буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-4, дунд-1 байна. Шалгалтад Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн үйл ажиллагааг 03/6.1-3 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 47.4, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 54.2-той буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд “их”, 03/6.1-6 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 53.3, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 46.2-той буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд “дунд” байна. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, шалгалтын мөрөөр зохих ажлыг эрчимжүүлэх чиглэлээр улсын ахлах байцаагчийн хамтарсан 51 заалт бүхий 8 албан шаардлага, 1 албан даалгавар өгч, биелэлтийг тооцон ажиллахаар боллоо. Боловсролын сургалтын байгууллагад тавигдах шаардлага зөрчсөн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуульд 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох		
--	--	--	--	--	--	--	--

					шийтгэлийг оногдуулсан. Хавсралт: 1 файл		
6	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	-	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь - 100%	Тайлант хугацаанд https://mongolianeducation.sharepoint.com/ системээр 7 албан бичиг, 35 өргөдөл, гомдлыг хүлээн авч төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамж 8, танилцуулга 3, албан бичиг 14-ийг тус тус албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж, шалгалтад боловсролын сургалтын 21 байгууллагыг хамруулж ажиллалаа. Шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн албан шаардлага 5-ыг боловсруулан холбогдох байгууллагуудын удирдлагад хүргүүлж, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дэх хэсгийг буюу өргөдөл гомдолд тавих шаардлагыг хангаагүй 1, мөн хуулийн 14.1, 14.2 дахь хэсгүүдийг хангаагүй буюу сургуулийн нэрийг нууцалсан 2 гомдлыг хянан үзэлгүйгээр шийдвэрлэж, Боловсролын ерөнхий хуулийн 28.2.4-т заасан чиг үүргийн хүрээнд Завхан аймгийн Боловсролын газарт 2025.05.16-ны өдрийн 11/2104 тоот албан бичгээр 3, Нийслэлийн Боловсролын газарт 2025.04.28-ны өдрийн 11/1740 тоот албан бичгээр 1, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 12.2-т заасан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Хүнс, хөдөө аж	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ахуйн газарт 2025.04.14-ний өдрийн 11/1488 тоот албан бичгээр 1 буюу нийт 5 гомдлыг харъяаллын дагуу шалгуулахаар шилжүүлсэн. Хавсралт: 5 файл		
3.1. Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.							
7	Хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Сургалт зохион байгуулсан тоо Хамрагдсан улсын байцаагч	-	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 2 Сургалт зохион байгуулсан тоо - 1 Хамрагдсан улсын байцаагч - 30	Боловсролын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Сүхбаатар аймагт төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийх явцад аймгийн Боловсролын газрын боловсролын хяналтын улсын байцаагч А.Ууганцэцэгийн үйлдсэн эрх зүйн баримт бичиг, түүний биелэлттэй танилцан мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Дархан-Уул аймгийн Боловсролын газрын боловсролын хяналтын улсын байцаагч Н.Мягмаржаргалд улсын байцаагчийн үйлдэх баримт бичгийн жишээ загварыг танилцуулж, өргөдөл гомдол хэрхэн анализ хийж ажиллахыг зааварчилж, туршлагаа хуваалцсан. Нийслэлийн Боловсролын газрын боловсролын хяналтын улсын байцаагчдад тогтмол мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.2. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.							
8	Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж,	Хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна.	-	Гүйцэтгэлийн төлөвлөгөө - 0 Тайлагналт - 3	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.07-ны өдрийн Б/54 дугаарын тушаалаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	батлуулах, хэрэгжилтийг сар, улирлаар тайлагнах				батлуулсан. Нийт 5 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, хэрэгжилтийг 4, 5 дугаар саруудад тайлагнан ажилласан.	10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь мэдүүлэх	Хуульд заасан хугацаанд мэдүүлсэн байна.	-	1	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчийн ХАСХОМ-ийг цаг хугацаанд нь тайлагнасан.	4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
10	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг	Өргөдөл, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	-	Шийдвэрлэлтийн хувь - 100%	Томилогдон ажилласан 2 сарын хугацаанд 7 албан бичиг, 35 өргөдөл, гомдлыг хүлээн авч төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамж 8, танилцуулга 3, албан бичиг 14-ийг тус тус албан хэрэг хөтлөлтийн стандартын	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх				дагуу боловсруулж, шалгалтад боловсролын сургалтын 21 байгууллагыг хамруулж ажиллалаа. Шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн албан шаардлага 5-ыг боловсруулан холбогдох байгууллагуудын удирдлагад хүргүүлж, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дэх хэсгийг буюу өргөдөл гомдолд тавих шаардлагыг хангаагүй 1, мөн хуулийн 14.1, 14.2 дахь хэсгүүдийг хангаагүй буюу сургуулийн нэрийг нууцалсан 2 гомдлыг хянан үзэлгүйгээр шийдвэрлэж, Боловсролын ерөнхий хуулийн 28.2.4-т заасан чиг үүргийн хүрээнд Завхан аймгийн Боловсролын газарт 2025.05.16-ны өдрийн 11/2104 тоот албан бичгээр 3, Нийслэлийн Боловсролын газарт 2025.04.28-ны өдрийн 11/1740 тоот албан бичгээр 1, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 12.2-т заасан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт 2025.04.14-ний өдрийн 11/1488 тоот албан бичгээр 1 буюу нийт 5 гомдлыг харъяаллын дагуу шалгуулахаар шилжүүлсэн.	10-р сар, 11-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1 1	Цаг үеийн нөхцөл шаардлага болон дээд шатны байгууллага,	Цаг хугацаанд нь хийж хэрэгжүүлсэн байна.	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100%	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2025.04.19-ний өдрийн 10-00/23 дугаартай удирдамжийн дагуу улаанбурхан өвчин бүртгэгдсэн, өвчлөлийн нууц үеийн хугацаа дуусаагүй	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	удирдлагаас өгсөн хууль ёсны шийдвэрийн дагуу ажил үйлчилгээг гүйцэтгэх				нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Шалгалтад сургуулийн өмнөх боловсролын 5 байгууллага, ерөнхий боловсролын 33 сургууль буюу нийт 38 байгууллагыг хамруулж, шалгалтын явцад ирцийн бүртгэлд хичээлд ирээгүй суралцагчдын нэрсийг бичдэггүй, шалтгааныг тодруулан тодорхой бүртгэдэггүй, эмч нар Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаагүй, анги удирдсан багш, сургуулийн эмч, нийгмийн ажилтнууд нь улаанбурхан өвчний хам шинж, сэжигтэй тохиолдлыг илрүүлэх тандалтыг хийгээгүй, улаанбурхан өвчнөөр өвчилсөн хүүхдийн судалгааг бүрэн гаргаагүй, бүртгэл судалгаагүй, дархлаажуулалтад хамрагдаагүй суралцагчдын судалгааг нэгтгэж, баталгаажуулаагүй зэрэг нь дутагдлуудыг илрүүллээ. Дүнг үндэслэн улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлагыг нийслэлийн ерөнхий боловсролын 31, 45 дугаар сургуулийн удирдлагуудад хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллалаа. Шалгалтын дүнгийн танилцуулгыг нэгтгэн, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газарт 2025.05.05-ны өдрийн 11/1869 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хавсралт: 2 файл	сар, 11- р сар	үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	--	--	--	-------------------	---

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
---	-----------------	---------------	---------

1	2	3	4
---	---	---	---

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, дүрэм журмын хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чадвараа дээшлүүлэх	Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Мэргэжлийн чадвараа дээшлүүлнэ.	-	Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чадвар дээшилсэн байна.	- Улсын ерөнхий Прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн хэрэглэгч болох боловсролын хяналтын улсын /ахлах/ байцаагчдад зориулсан сургалтад 2025.05.23-ны өдөр хамрагдсан. - Яамны Төрийн захиргаа, удирдлагын газраас зохион байгуулсан: Төрийн албан дахь ёс зүйн боловсрол, харилцаа хандлагыг эерэгжүүлэх техник оролцоонд тулгуурласан сургалт, Хувь хүн, байгууллагын кибер аюулгүй байдал, Ажлын байрны ёс зүй, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль болон Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийн талаар сэдэвт сургалт, мэдээлэлд	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

					хамрагдсан.		
2	Мэдлэг, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдах	Яам болон холбогдох газруудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана.	-	Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна.	Эрхэлсэн ажлынхаа мэдлэгийг дээшлүүлэх үүднээс Монголын стандарт, чанарын хүрээлэнгээс зохион байгуулсан ISO:9001-Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудиторын сургалтад хамрагдаж гэрчилгээжсэн.	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%
3	Монгол хэлний тухай хуулийн дагуу Төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөн явуулахаар болсонтой холбогдуулан монгол бичгийн чадвараа сайжруулах	Монгол бичгийн унших, бичих чадвараа бие даан сэргээн улам сайжруулах	Монгол бичгийн унших, бичих чадвар дунд шатны мэдлэгтэй.	Монгол бичгийн унших, бичих чадвараа сайжруулсан байна.	Монгол бичгийн унших, бичих чадвараа бие даан сэргээн улам сайжруулж байна.	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боловсролын салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Алтантүлхүүр Танан-Эрдэнэ /...../

Огноо: